



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№139 /353/

2022.08.09

Цаг үе, үйл явдал

НҮБ-ЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ТӨГӨЛД МОД ТАРИВ



оливын мод гэсэн үг. Би өвөг эцгийнхээ нэрийг уламжилж авсан, хоёр овогтой хүн. Манай өвөг эцэг намайг жоохон байхад тариалангийн талбайд дагуулж очоод жижигхэн оливын модыг харуулаад "Энэ модыг чамайг төрөхөд суулгасан юм. Чамайг бүх насаараа модыг эрхэмлэж, хүндэлж яваасай гэж хүсэж байна. Нэг мод тарихдаа заавал хажууд нь нэг мод тарих ёстой" гэж надад сургасан. Тэгээд "Чи мод таривал тэр мод чинь чиний амьдралын илэрхийлэл болно" гэж хэлсэн. Оливын мод олон жил насалдаг. Манай Португалд 1000 гаруй жил насалсан оливын мод байдаг. Би 1000 жил насална гэж байгаа юм биш. Гэхдээ миний амьдралыг илэрхийлсэн мод миний эх оронд ургаж байгаа гэдэг нь сайхан санагддаг.

Монгол Улс нэг тэрбум мод тарина гэдэг нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад, цөлжилттэй тэмцэхэд,

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн урилгаар манай оронд албан ёсны айлчлал хийж буй НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зочилж Энхийг сахиулагчдын төгөлд мод тариллаа. Тус арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор тэргүүтэй албаны зочид төлөөлөгч болон энхийг сахиулагчдын төлөөлөл оролцлоо.

Энэ үеэр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш "Мод тарих ажиллагааны нээлтийн үгийг хэлэхээсээ өмнө энд цугласан энхийг сахиулагчдад хүндэтгэл үзүүлэхийг хүсэж байна. Дэлхийн хамгийн халуун цэгүүдэд, хамгийн хүнд, хэцүү байдалд байгаа улс орнуудад Монголын цэргүүд энхийг сахиулах ажиллагаанд оролцож, тэнд байгаа эмэгтэйчүүд, энгийн иргэд, эмзэг бүлгийнхэнд бүхий

л талын дэмжлэг туслалцаа үзүүлж ирсэн та бүхний үйл хэргийг би өндрөөр үнэлж байна. Мөн энд хуран цугласан хүүхэд залуудад баяр хүргэхийг хүсэж байна. Танай Ерөнхийлөгч надад "Монголын хүүхэд залуучууд бол байгаль орчноо хамгаалах үйлсэд маш идэвхтэй оролцдог" гэж хэлсэн. Та бүхний энэ үйл хэргийг талархан хүлээн авч байна. Бидний үеийнхэн байгаль орчиндоо ариг гамтай хандаж чадаагүй. Бид байгаль орчноо бохирдуулсан, байгалийнхаа баялгийг авч хэрэглэсэн, байгаль орчноо хойч үеийнхэндээ сайхнаар нь хүлээлгэн өгч чадсангүй. Энэ алдааныхаа үр дагаврыг одоо амсаж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчноо хамгаалахыг залуучууд та бүхнээс гуйж байна. Бидний үеийнхэнд та бүхэн туслаач, ирээдүйн хойч үеийнхэндээ илүү сайхан, илүү эрүүл байгаль орчныг хүлээлгэж өгөөч гэж та бүхнээс хүсэж байна.

2030 он гэхэд нэг тэрбум



мод тарина гэсэн сайхан санаачилга өрнүүлсэн Ерөнхийлөгч танд баяр хүргэе. Таны санаачилгад хувь нэмрээ оруулах боломж олгосонд баярлалаа. Би уг нь энэ арга хэмжээнд зориулж үг бэлдсэн юм. Гэхдээ тэр үгээ уншихаа болилоо. Яагаад гэвэл, би өөрийнхөө амьдралд тохиолдсон түүхээс хуваалцвал илүү сонирхолтой байх гэж бодож байна. Миний ээжийн маань аав буюу миний өвөг эцэг Оливера гэдэг овогтой байсан. Үүнийг португал хэлнээс орчуулбал

биологийн олон янз байдлыг хадгалж хамгаалж үлдэхэд чухал хувь нэмэр оруулна гэж итгэж байна. Байгаль орчин болон хүн төрөлхтний хоорондын холбоосыг нэг тэрбум мод тарих үйл ажиллагаа дахин сэргээн гэж ойлгож байна. Энэ холбоос бат бөх байх ёстой. Гэтэл бид энэ холбоосыг тасалсан байна. Үүнийг нөхөн сэргээхэд нэг тэрбум мод чухал үүрэг гүйцэтгэн гэж бодож байна" гэлээ.

НҮБ-ЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА А.ГУТЕРРЕШ



1949 оны 04 дүгээр сарын 30-нд Португал Улсын Лиссабон хотноо төрсөн. Португал Улсын Парламентын гишүүн, Европын Зөвлөл дэх Португал Улсын төлөөлөгч, Европын Зөвлөлийн Ерөнхийлөгч, Социалист намын Ерөнхий нарийн бичгийн дарга, Социалист Интернационалын Дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгч, Португал Улсын Ерөнхий сайд, Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн НҮБ-ын Дээд комиссарын алба хашиж байсан.

2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс НҮБ-ын ес дэх Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хангах, энхийн зуучлагч болж, шинэчлэл, инновацыг хөхиулэн дэмжихийг гол зорилго болгон ажиллаж байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын түвшинд Монгол Улсад дөрвөн удаа айлчилж байснаас хамгийн сүүлд буюу 2009 онд Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүүн айлчилсан түүхтэй.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 24	🌧️ 13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.190.00	3.200.0
EUR 🇪🇺	3.260.0	3.285.0
CNY 🇨🇳	472.00	475.00
RUB 🇷🇺	49.20	50.20
JPY 🇯🇵	23.50	24.00
KRW 🇰🇷	2.41	2.43

ЗУРХАЙ



2022.08.09 /МЯГМАР ГАРГАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 12

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХ МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:
Өвчин эмгэг ирнэ.
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.39-20.17
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Хүрэлцэхүй
Суудал: Төмөр

Энэ өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, гарагийг тахиж, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 590,377,658

Эдгэрсэн
Нийт: 562,156,324

Нас барсан
Нийт: 6,438,884

МОНГОЛЫН ТАНКЧИД “УЛААН” ӨНГИЙН ТАНКААР УРАЛДАНА

Оросын Холбооны Улсын Батлан хамгаалах яамнаас “Олон улсын цэргийн наадам” тэмцээнийг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай бөгөөд манай улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид өнгөрсөн жилүүдэд дээрх наадмын хүрээнд явагддаг зарим тэмцээнд амжилт дүүрэн оролцсоор ирсэн юм.

Энэ удаа “Олон улсын цэргийн наадам-2022”-ын “Танкийн биатлон” болон “Армийн соёл, урлаг” төрөлд оролцох Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид Оросын Холбооны Улсын Москва хотноо хүрэлцэн очиж, тэмцээний өмнөх бэлтгэл ажилдаа орсон байна.

Тус тэмцээнд оролцох бүрэлдэхүүнийг “Олон улсын цэргийн наадам”-ыг зохион байгуулах хорооны гишүүн, Монголын талын дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын дарга бригадын генерал С.Дашзэвэг удирдаж байгаа юм.

Энэ сарын 8-ны өдөр “Танкийн биатлон” тэмцээнд оролцох баг, тамирчид танкны өнгө, гарааныхаа дарааллыг сонгох сугалааг сугалсан ба манай улсын Зэвсэгт хүчний баг, тамирчид “улаан” өнгийн танкаар нэгдүгээр дивизионд Азербайжаны багтай эхний уралдаанд өрсөлдөхөөр болжээ.

Уг тэмцээний дүрмээр оролцогч орнууд хоёр дивизионд хуваагдах бөгөөд эхний дивизионд түрүү жилийн тэмцээнд амжилттай оролцсон 10 багийг багтаадаг бол хоёрдугаар дивизионд анх удаа оролцож байгаа болон чансаа сул багийг оруулснаар уралдааныг зохион байгуулдаг ажээ. Энэ жилийн хувьд тус тэмцээнийг үндсэн зохион байгуулагч Оросын Холбооны Улсаас гадна Хятад, Вьетнам, Лаос, Казахстан, Иран, Сири, Венесуэл зэрэг нийт 21 орны 63 танкийн экипаж оролцож байна.

Сонирхулахад,

манай улсын баг тамирчдын өрсөлдөхөөр болсон нэгдүгээр дивизионд өнгөрсөн жилийн наадамд чансаагаараа тэргүүлсэн Орос, Хятад, Казахстан, Беларус, Азербайджан, Узбекистан, Вьетнам, Киргизстан, Венесуелийн экипажууд багтсан аж.

Тэмцээний сугалааг сугалах энэхүү ажиллагаа нь монгол үндэсний хөөмийн аялгуугаар эхэлсэн нь оролцогчдын бахархлыг төрүүлсний зэрэгцээ манай баг тамирчдын хувьд эх орон, Зэвсэгт хүчин, үндэсний соёл, урлагаа сурталчлах чиглэлээрх эхний алхам болжээ.

Тэрчлэн “Армийн соёл, урлаг” тэмцээнд анх удаа оролцох Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын дуучид, бүжигчид болон хөгжимчид тайзан дээрх бэлтгэлдээ оржээ. Мөн Монгол цэргийн музейн хувьд үзэсгэлэн дэглэх газар талбайгаа судлан эд өлөг, үзмэрүүдээ бэлтгэж буй мэдээг бидэнд ирүүлсэн юм.



Цахим шууданд

ЗИМБАБВЕ УЛСЫН БАГ ТАМИРЧИД ХҮРЭЛЦЭН ИРЛЭЭ



“Олон улсын цэргийн наадам”-ын нэг төрөл “Аравт-2022” олон улсын морин цэргийн уралдаанд оролцохоор Бүгд Найрамдах Зимбабве улсын цэргийн алба хаагчид 8 дугаар сарын 9-ний энэ өдөр Монгол Улсад хүрэлцэн ирлээ.

Баг тамирчдыг “Аравт-2022” олон улсын морин цэргийн уралдаан зохион байгуулах хорооны дарга, Ерөнхий шүүгч, хурандаа Д.Цог-Эрдэнэ Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд угтан авч, уралдааны бэлтгэл ажлын явцын талаар мэдээлэл хүргэсэн юм. Тэрээр “Манай сайхан оронд тавтай морил. Монгол Улсын Зэвсэгт хүчин дэлхийн улс орнуудын Зэвсэгт хүчнүүдийн хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, итгэлцэл, нөхөрлөлийг бэхжүүлэх найрамдлын гүүр болж “Аравт” уралдааныг “Олон

улсын цэргийн наадам”-ын хүрээнд 2019 онд анхлан зохион байгуулахад ажиглагчаар оролцож байсан Бүгд Найрамдах Зимбабве улс энэ удаа оролцогчийн статустайгаар баг тамирчидтайгаа манай сайхан оронд хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлье” гээд уралдаан 8 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд албан ёсоор явагдана. Үүний өмнө бэлтгэл



ажлыг бүрэн хангаж, явагдах газар орон, маршруттай танилцах, мориндоо дасах сургалтуудыг тасралтгүй явуулах талаар мэдээлэл өгсөн юм.

Ташрамд дурдахад, Монгол Улс нь 1984 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Бүгд Найрамдах Зимбабве улстай дипломат найрамдалт харилцаа тогтоож байсан түүхтэй билээ.

ЦЭРГИЙН ЗАЛУУСАА ЭРГЭВ

Сүхбаатар дүүргийн Засаг дарга Х.Болормаа албаны хүмүүсийн хамт Зэвсэгт хүчний 326 дугаар ангид алба хааж буй залуусаа эргэв.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас цэргийн алба хааж буй дайчдынхаа албаны нөхцөл байдалтай танилцах, санал хүсэлтийг нь сонсох зорилгоор энэхүү уулзалт, өдөрлөгийг зохион байгуулж байгаа юм.

Хурандаа Г.Отгонбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Зенитийн артиллерийн дивизионы хугацаат цэргийн алба хаагчдын 50 гаруй хувийг Сүхбаатар дүүргээс татагдсан цэргүүд эзэлж байна.

2021 оны хоёрдугаар ээлж, 2022 оны нэгдүгээр ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан залуус маань албаа нэр төртэй хааж байна.

Тус ангиас алба хаагчдынхаа өөрийгөө нээн хөгжүүлэх, бие биенээсээ суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрөл бүрийн дугуйлан хичээллүүлдэг.

Ангийн захирагчийн тушаалаар үлээвэр найрал хөгжмийн салааг байгуулан бие даасан анхны тоглолтоо нийт бие бүрэлдэхүүнд болон ар гэрийнхэндээ зориулан тогложээ. 90 гаруй албан хаагч В,С ангиллын жолооны сургалтад суусны 46 нь Сүхбаатар дүүргийн залуус байна. Тэд жолооч мэргэжилтэй халагдах нь.

Мөн алба хаагчдын сургалт, өдөр тутмын мэдээг ар гэрт нь өгдөг, санал, хүсэлтийг хүлээн авдаг фейбүүкийн хаалттай группыг хөтөлж байгаа нь олны талархлыг хүлээсэн ажил болжээ.

Энэ удаа гэрээт цэргийн албанд үлдэхээр 27 залуу саналаа өгснөөс 16 нь мөн Сүхбаатар дүүргийнх байна гэх мэтчилэн талархалтай олон ажлыг зохион байгуулж байна.

Цаашид Сүхбаатар дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас батлан



хамгаалах хууль, тогтоомжоор хүлээсэн үүргийнхээ хүрээнд тус ангитай олон чиглэлд

хамтран ажиллах, харилцан дэмжлэг үзүүлэх тал дээр санал нэгдлээ.